



**ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ  
ХУВЬЦААТ КОМПАНИ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
1 дүгээр хороо, Жигжиджавын гудамж 8, Финанс төв  
Утас: 7505-5555

И-мэйл: info@erdenestt.mn, Вэбсайт: www.ett.mn

2024-10-17 № 01/2131

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**ТЕНДЕРТ ОРОЛЦОХЫГ  
СОНИРХОГЧ ЭТГЭЭДҮҮДЭД**

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

“Эрдэнэс Тавантолгой” ХК-аас зарласан ЭТТХК/20240101017 дугаартай “Чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хучилт, бетон талбайн ажил гүйцэтгэгчийг сонгох тендер шалгаруулалтай холбоотой тендерт оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгын хариуг хүргүүлж байна. Үүнд:

Тендерийн нэр	Чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хучилт, бетон талбайн ажил гүйцэтгэгчийг сонгох
Тендерийн дугаар	ЭТТХК/20240101017
Тендер зарласан огноо	2024 оны 09 дүгээр сарын 25
Тендер нээх огноо	2024 оны 10 дугаар сарын 17

Тодруулга	Хариу
<p>Танай компаниас зарласан ЭТТХК/20240101017 дугаартай “чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хучилт, бетон талбайн ажил” тендерийн шалгаруулалтад оролцож байна.</p> <p>Тендерийн баримт бичиг болон ажлын зургаас доорх тодруулга авч байна.</p> <p>Үүнд: Тус тендер нь доорх тусгай зөвшөөрлийн шаардлага тавьсан.</p> <p>2.8.2.2 Хайрган хучилттай зам барих 2.8.2.6 Зам, талбайн тохижилтын ажил хийх, засварлах</p> <p>Энэхүү шаардлага нь Зам, тээврийн хөгжлийн яамны А/177 тоот сайдын тушаалын дагуу шинэчлэгдэн өөрчлөгдсөн тул энэ тушаалын дагуу Авто зам, замын байгууламжийг барих, засварлах, арчлах ажлын хүрээнд 5.2.3.4 дугаартай Авто зам замын байгууламж арчлах тусгай зөвшөөрлөөр тухайн тендерт оролцож болох эсэхэд тодруулга өгнө үү.</p> <p>Зам тээврийн хөгжлийн яамны А/177 тоот сайдын тушаал.</p>	<p>2023 оны 06 сарын 08 өдрийн Зам тээврийн сайдын тушааллаар тусгай зөвшөөрөл хүсэгч этгээдэд тавих нэмэлт шаардлага батлах тухай А/177</p> <p>2.8.2.2 Хайрган хучилттай авто зам барих 2.8.2.6 Авто машины зогсоол, талбайн тохижилт ажил хийх, засварлах</p> <p><i>/Хуучин журам шинэчлэгдсэн ч тусгай зөвшөөрлийн хугацаа нь дуусах болоогүй аж ахуйн нэгжийн хувьд тооцно./</i></p> <p>Шинэчилсэн журмын доорх 2 заалтын аль нь ч байж болно.</p> <p>5.2.3.1 Автозам барих - Бүх төрлийн асфальт бетон, цемент бетон, хөнгөвчилсөн хучилттай автозам барих, их засвар, шинэчлэлт</p> <p>5.2.3.4 Автозамын байгууламжийг арчлах - Бүх төрлийн асфальт бетон, цемент бетон, хөнгөвчилсөн хучилттай автозам, замын байгууламжийн арчлалт, урсгал засвар, талбайн тохижилт, тэмдэг, тэмдэглэгээний ажил</p> <p>/Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.06.08-ны А/177 дугаар тоот тушаалын</p>

1124043939

	<p>хавсралтын 3-р бүлэгт заагдсан талбайн тохижилтын ажил хамаарагдаж байна./</p> <p>Иймд дээрх хуучин болон шинэ журмын тус 4 заалтад хамаарах тусгай зөвшөөрөл байж болно.</p>
<p>Танай компаниас зарласан ЭТТХК/20240101017 дугаартай “чингэлэг тээврийн терминалын өргөтгөл, гаалийн хяналтын бүсийн талбайн хучилт, бетон талбайн ажил” тендерийн шалгаруулалтад оролцож байна.</p> <p>Тендерийн баримт бичиг болон ажлын зургаас доорх тодруулгуудыг авч байна.</p> <p>Үүнд:</p> <p>1. Тус тендер нь доорх 2 багц тендэртэй.</p> <p>-ЭТТХК/20240101017-1 багцын дугаартай “Гашуунсухайт боомтод байрлах чингэлэг тээврийн терминалын өргөтгөлийн 16га талбайд уурхайгаас ирсэн болон уртын тээвэрт гарах тээврийн хэрэгслүүдийн зогсоол, чингэлэг шилжүүлэн ачих, чингэлэг түр хадгалах талбайг байгуулах”</p> <p>-ЭТТХК/20240101017-2 багцын дугаартай “Цагаанхад суурьшлын бүсэд байрлах “эрдэнэс” гаалийн хяналтын бүсийн 12,31га талбайд чингэлэг ачих, буулгах талбайг байгуулах”</p> <p>ТШЗ 2.1-д</p> <p>Нийт төсөвт өртөг: 8,372,919,818 /найман тэрбум гурван зуун далан хоёр сая есөн зуун арван есөн мянга найман зуун арван найм/ төгрөг</p> <p>Багц-1 төсөвт өртөг: 4,668,468,000 /дөрвөн тэрбум зургаан зуун жаран найман сая дөрвөн зуун жаран найман мянга/ төгрөг</p> <p>Багц- 2 төсөвт өртөг: 1,932,292,000 /нэг тэрбум есөн зуун гучин хоёр сая хоёр зуун ерэн хоёр мянга/ төгрөг буюу 2 багцуудын нийлбэр төсөвт өртөг нь дээрх нийт төсөвт өртгөөс 1.772.159.818 /нэг тэрбум долоон зуун далан хоёр сая нэг зуун тавин есөн мянга найман зуун арван найм/ төгрөг зөрүүтэй байна.</p> <p>1. Мөн зураг төсөлд заасан ухмал, хөрс хуулалт, далан, шуудуу, суурийн үе болон хайрган хучилтын ажлыг гүйцэтгэх үед:</p> <p>-Ухмалын материалыг хэдэн километр тээвэрлэж зайлуулах</p> <p>-Далан, суурь, хайрган хучилтанд ашиглах тохиромжтой материалыг хэдэн километрээс тээвэрлэх,</p> <p>-Технологийн ажил гүйцэтгэхэд шаардлагатай усан хангамжийн тээврийн зай гэх мэт төсөв бодоход шаардлагатай тээврийн зайнуудыг тус бүр тодорхойлж, байршил /координат/ -ыг тодорхой болгох.</p> <p>1. Тоо хэмжээнд тусгаагүй нүүлгэн шилжүүлэлтийн зардлыг хэрхэн тооцох.</p> <p>2. ГША гүйцэтгэх үед тээврийн түр замыг төсөвт хэрхэн тооцох.</p>	<p>1.Тухайн тендер шалгаруулалтын нийт төсөв 8,372,919,818 /найман тэрбум гурван зуун далан хоёр сая есөн зуун арван есөн мянга найман зуун арван найм/ төгрөг бөгөөд тухайн төсөл арга хэмжээний Багц 1,2 эхний ээлжинд зарлаж байгаа болно.</p> <p>2.Тодруулгын хариуг хавсралт 1,2-р хүргүүлэв.</p>

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасныг үндэслэн тендер нээх өдрийг 2024 оны 10 дугаар сарын 24-ны өдрийн 10:30 цаг болгон өөрчилж байгааг мэдэгдье.

Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны 10.3-т заасны дагуу дээрх нэмэлт өөрчлөлтүүд нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН  
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



Х.МӨНХЖАРГАЛ